Төсвийн тодотголоор санхүүжилтийн эх үүсвэрийг 802,469.6 мянган төгрөг, үүнээс урсгалд зардалд 802,469.6 мянган төгрөгийн зарцуулалтыг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 802,469.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 802,469.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, урсгал үйл ажиллагаанд 745,086.7 мянган төгрөгийг зарцуулж, 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 745,086.7 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 3,002.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 51,263.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 272.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70201	Чөлөөт бүсийн хөгжүүлэх	802,469.6	745,086.7	57,382.8	92.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	758,792.8	701,410.3	57,382.4	92.4
1.2	80226	Байр ашиглалтын зардал	26,512.7	26,512.7	-	100

1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	17,164.1	17,163.7	400.0	100
1.4	80918	Бусад хөрөнгийн зардал	7,751,699.9	7,751,699.9	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтын дансанд үндсэн үйл ажиллгааны хүрээнд бий болсон орлого 138,924.0 мянган төгрөг, Замын-Үүд дулааны станц зүгшрүүлэлтийн ажлын санхүүжилт 1,460,584.3 мянган төгрөг, нийт 1,599,508.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 37,456.5 мянган төгрөг, цалин нэмэгдэл, НДШ-ийн зардалд 23,475.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 17,854.9 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 42,489.8 мянган төгрөг, томилолтын зардалд 12,135.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,460,584.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 4,131.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Монгол улсын засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 189 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд барьсан Дулааны станц, Ус хангамж, ариутгах татуургын туршилт, тохируулга хийхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэхээр Замын үүдийн Дулааны станц ТӨҮГ-тай хийсэн 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн №01/17 тоот гүйцэтгэлийн гэрээ хийгдэж, тайлант онд нийт 1,460,580.3 мянган төгрөгний санхүүжилт олгогдсон байна. Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь тухайн гүйцэтгэлийн тайланд хяналт тавьж ажилладаггүй, санхүүжилтийг гүйцэтгэлийн тайлангаар олгодог бөгөөд Төрийн сан, Шадар сайдын албанд тайланг хянуулж, санхүүжилтийг авдаг.

3.8 Аудитын гол асуудал

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь нийт 4,312,205.4 мянган төгрөгийн 148 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 22 мэдээллийг хугацаа хоцроож, 255,988.4 мянган төгрөгийн 12 удаагийн ажил гүйлгээг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас (цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл) бусад төрлийн зардлыг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" 1.9-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.1 заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 594,543.2 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрүүлснээс 8,649.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 585,893.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгч, жилийн эцсийн аудитаар дахин хянахад 5 зөвлөмжийг хэрэгжүүлж залруулсан, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээг хугацаа хоцроож, 3 мэдээг байршуулаагүй, дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй зөрчилд 2 албан шаардлагын биелэлт 50 хувь, 6,418.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	1	-	1	-	50
Төлбөрийн акт	1	13,990.6	1	13,990.6	-	-	-
Зөвлөмж	2	6,418.4	2	6,418.4	-	-	100
Нийт дүн	5	30,450.0	4	26,585.4	1	-	75

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хугацаа хоцроосон, байршуулаагүй, дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй зөрчил давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Засгийн газрын 2019 оны 207 дугаар тогтоолоор Хил хамгаалах ерөнхий газар, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Хилийн 0119 дүгээр анги /ТӨААТҮГ/-ын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр хамтарсан гэрээний дагуу “Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн систем”-ийн ажлыг хийж гүйцэтгэхэд зарцуулагдсан нийт 10,751,698.0 мянган төгрөгний санхүүжилт бүрэн батлагдаж, ажлын гүйцэтгэлийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн хөрөнгийн бүртгэл, Хил хамгаалах ерөнхий газарт балансар шилжүүлэх асуудлыг холбогдох газруудад танилцуулж зөвшөөрөл авсан эсэх, шийдвэр гаргалт болон тус албаны үндсэн хөрөнгийн бүртгэлийг хянах;
2. Дулааны станц, Ус хангамж, ариутгах татуургын туршилт, тохируулга хийх ажлын Замын үүдийн Дулааны станц ТӨҮГ-тай хийсэн 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн №01/17 тоот гүйцэтгэлийн гэрээг дүгнэж, ажлыг хүлээлцсэн актыг хянаж, санхүүгийн тайланд тусгасан эсэх, гэсэн асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 85,471.5 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 8,649.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 76,821.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж, 1 сахилгын хариуцлага тооцуулахаар өглөө.

Залруулагдаагүй 76,821.8 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 40,339.6 мянган төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Балансад шилжиж ирсэн 3,000.0 мянган төгрөгийн дансны үнэтэй Ниссан максима автомашинд ашигласан хугацааны элэгдэл тооцоогүй;
- Тайлант хугацаанд худалдаж авсан 1,595.0 мянган төгрөгийн Санхүүгийн Acolous программыг хөрөнгөөр бүртгээгүй шууд зардалд бичсэн;
- Бараа материалын орлогыг бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилж бүртгээгүй бусад хангамжийн материалын дансанд бичиг хэрэг, тос масло, сэлбэг хэрэгсэл зэрэг дансдын нийт 3,445.5 мянган төгрөгийн орлогыг буруу ангилж орлогодон 3,525.9 мянган төгрөгийн материалыг зарцуулж тайланг бэлтгэсэн байна.

4.2 Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Дотоод хяналтын мэргэжилтэн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дотоод хяналт шалгалт явуулах жилийн төлөвлөгөөний дагуу ажлыг хийж гүйцэтгэх, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Тус байгууллага нь санхүүгийн тайлагналдаа мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг тухай бүр тусгаж өгөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлж, ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хууль тогтоомжийн өөрчлөлтийг оруулж, шинэчлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Зардалтай холбоотой

Илрүүлэлт:

Замын-Үүд чөлөөт бүсийн 2019 онд актлагдсан хамгаалалтын хашааны төмрөөр бартердаж авсан Замын-Үүд суманд байршилтай 2 өрөө орон сууцыг үндсэн хөрөнгөд бүртгэгдээгүй, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр гараагүй байхад 19,900.00 мянган төгрөгний урсгал засварыг хийлгэсэн байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 4.3-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд Төсвийн тухай хуулийн болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг эзэмшүүлэх эсэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шийдвэрлэх бөгөөд тухайн хуулийн этгээдийн эзэмшигчдийн өмч болон холбогдох бусад дансанд бүртгэх зөвшөөрөл олгоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн дансанд бүртгэлгүй үндсэн хөрөнгөнд урсгал зардал гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх.

3. Дотоод хяналт үйл ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт:

Дээд шатны байгууллагаар байгууллагын бүтэц орон тоог 2015 оноос хойш тогтоолгоогүй, цалин, нэмэгдлийг жил бүр шинэчлээгүй Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 93 дугаар тушаалаар баталсан бүтэц орон тооноос 7 албан тушаалтан илүү, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалтан бий болгож цалин нийгмийн даатгалын зардал нийт 56,921.8 мянган төгрөгний зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.12-т “Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох”, гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүтэц орон тоог шинэчлэн батлуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Санхүүгийн тайлантай холбоотой

Илрүүлэлт:

Байгууллагын санхүүгийн байдлын тайлангийн Төрийн өмчийн дүн, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх Төрийн өмчийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “Хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчид гарсан өөрчлөлтийг хийлгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

5. Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт:

Шатахууны тооцоог хийхдээ жолооч нарын тооцоог боддоггүй, түлш шатахууны хэмнэлт хэтрэлтийг тооцоогүй нийт дүнгээр зардалд бичдэг, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн

Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэх анхан шатны маягт хөтлөх зааварын 6.4-т "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ", "Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэсэн заасныг мөрдөж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл хангасан баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэх, зардлыг хүлээн зөвшөөрч тайлан бэлтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
							Залруулга		Зөвлөмж		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	ЗҮЧБЗ АА	АХГ-2022/159/НА-СТА-ТШЗ	Тус байгууллага нь санхүүгийн тайлагналдаа мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг тухай бүр тусгаж өгөөгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хууль тогтоомжийн өөрчлөлтийг оруулж, шинэчлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1					1					
2	ЗҮЧБЗ АА	АХГ-2022/159/НА-СТА-ТШЗ	Замын-Үүд чөлөөт бүсийн 2019 онд актлагдсан хамгаалалтын хашааны төмрөөр бартердаж авсан Замын-Үүд суманд байршилтай 2 өрөө орон сууцыг үндсэн хөрөнгөд бүртгэгдээгүй, төрийн өмчийн	Хөрөнгийн дансанд бүртгэлгүй үндсэн хөрөнгөнд урсгал зардал гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх.	1	19,900.0				1	19,900.0				

			бодлого зохицуулалтын газрын шийдвэр гараагүй байхад 19,900.00 мянган төгрөгний урсгал засварыг хийлгэсэн.													
3	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА- СТА- ТШЗ	Дээд шатны байгууллагаар байгууллагын бүтэц орон тоог 2015 оноос хойш тогтоолгоогүй, цалин, нэмэгдлийг жил бүр шинэчлээгүй Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 93 дугаар тушаалаар баталсан бүтэц орон тооноос 7 албан тушаалтан илүү, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалтан бий болгож цалин нийгмийн даатгалын зардал нийт 56,921.8 мянган төгрөгний	Бүтэц орон тоог шинэчлэн батлуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	56,921.8			1	56,921.8						

			зардал гаргасан байна.													
4	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА- СТА- ТШЗ	Байгууллагын санхүүгийн байдлын тайлангийн Төрийн өмчийн дүн, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх Төрийн өмчийн дүн зөрүүтэй байна.	Улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчид гарсан өөрчлөлтийг хийлгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1				1							
5	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА- СТА- ТШЗ	Балансад шилжиж ирсэн 3,000.0 мянган төгрөгийн дансны үнэтэй Ниссан максима автомашинд ашигласан хугацааны элэгдэл тооцоогүй.	Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрч тайланд тусгах.	1	83.3	1	83.3								
6	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА- СТА- ТШЗ	Тайлант хугацаанд худалдаж авсан 1,595.0 мянган төгрөгийн Санхүүгийн Аcolous программыг хөрөнгөөр бүртгээгүй шууд зардалд бичсэн.	Холбогдох хууль тогтоомжыг мөрдөж ажиллах.	1	1,595.0	1	1,595.0								
7	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА-	Бараа материалын орлогыг бүртгэхдээ	Холбогдох хууль тогтоомжыг	1	6,971.4	1	6,971.4								

		СТА-ТШЗ	дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилж бүртгээгүй бусад хангамжийн материалын дансанд бичиг хэрэг, тос масло, сэлбэг хэрэгсэл зэрэг дансдын нийт 3,445.5 мянган төгрөгийн орлогыг буруу ангилж орлогодон 3,525.9 мянган төгрөгийн материалыг зарцуулж тайланг бэлтгэсэн байна	мөрдөж ажиллах.													
8	ЗҮЧБЗ АА	АХГ-2022/159/НА-СТА-ТШЗ	Шатахууны тооцоог хийхдээ жолооч нарын тооцоог боддоггүй, түлш шатахууны хэмнэлт хэтрэлтийг тооцоогүй нийт дүнгээр зардалд бичдэг, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт байхгүй, анхан шатны	Анхан шатны баримтын бүрдэл хангасан баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэх, зардлыг хүлээн зөвшөөрч тайлан бэлтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1					1							

			баримтын бүрдэл дутуу.													
9	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА- СТА- ТШЗ	Дотоод хяналтын мэргэжилтэн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийгээгүй байна. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргасан байна.	Байгууллагын дотоод хяналт шалгалт явуулах жилийн төлөвлөгөөний дагуу ажлыг хийж гүйцэтгэх, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох.	1								1		1	
Дүн					9	85,471.5	3	8,649.7	5	76,821.8			1		1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА- СТА- ТШЗ	Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь нийт 4,312,205.4 мянган төгрөгийн 148 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 22 мэдээллийг хугацаа хоцроож, 255,988.4 мянган төгрөгийн 12 удаагийн ажил гүйлгээг ил тод	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах.	1	255,988.4							1	255,988.4	1	255,988.4

			байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.												
2	ЗҮЧБЗ АА	АХГ- 2022/1 59/НА- СТА- ТШЗ	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайг аас (цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл) бусад төрлийн зардлыг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.	Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.	1							1			
Дүн					2	255,988.4						2	255,988.4	1	255,988.4
Нийт дүн					11	341,459.9	3	8,649.7	5	76,821.8		3	255,988.4	2	255,988.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 126/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/159/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас (цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл) бусад төрлийн зардлыг 10 хувийн хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтууд, Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.9 "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагч А.Энхзул, Бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга Ж.Баатарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Н.УРАНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-104.Docx

0010800359



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 125/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/159/НА-СТВ-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь нийт 4,312,205,436.99 төгрөгийн 148 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 22 мэдээллийг хугацаа хоцроож, 255,988,424.99 төгрөгийн 12 удаагийн ажил гүйлгээг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Ерөнхий нягтлан бодогч Г.Ганцэцэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагч А.Энхзул, Бүртгэл, санхүүгийн хэлтсийн дарга Ж.Баатарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

(Handwritten signatures)

Ц НАРАНЧИМЭГ
Б СЭРЖМЯДАГ
Н УРАНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

4006109
9019120396

D:\My Works\New Folder\0225 Auditin 2 Газар-103.Docx

0010800356



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 124/А0150058
АХГ-2022/159/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дотоод хяналтын мэргэжилтэн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргасан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2 “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын мэргэжилтэн Б.Үзмээд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагч А.Энхзул, Бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга Ж.Баатарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

(Handwritten signatures and red official stamps)

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Н.УРАНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

9019120596

10.10.2020 Bichig_Kherys_Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-102.Docx

0010800353

